



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/08

Бор-Өндөр сум

**Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх
энгийн зөвшөөрөл сунгах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Зөвшөөрлийн тухай хуулийн 2.1 дүгээр зүйлийн 1.2, 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35.1.5 дахь заалт, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын аравдугаар хуралдааны Тогтоолын хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Уурхайчин 4 дүгээр багт худалдаа эрхэлдэг "АРТЦАЦАЛ" ХХК-ийн "Бум-Эрдэнэ" хүнсний дэлгүүрийн тамхи худалдах энгийн зөвшөөрлийг 2025 оны 01 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн 3 (гурван) жилийн хугацаагаар сунгасугай.

2. Тамхи худалдах энгийн зөвшөөрлийн улсын тэмдэгтийн хураамж 350000 (гурван зуун тавин мянга) төгрөгийг зохих дансанд төвлөрүүлж ажиллахыг татварын Улсын байцаагч (Ц.Баясгалан)-д даалгасугай.

3. Энгийн зөвшөөрлийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уурхайчин 4 дүгээр багийн Засаг дарга (Ч.Саруулмөнх)-д, Бор-Өндөр сум дахь Сум дундын Цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа (Т.Энхбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ОТГОНЦЭЦЭГ